



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин,
аюулгүй байдал, орон нутаг

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-ПЛН-0001-М	Хувилбар: 2.0

ГАРЧИГ

1	ТАНИЛЦУУЛГА	4
1.1	Зорилго.....	4
1.2	Хэрэглээ.....	4
1.3	Эхлэх огноо.....	4
1.4	Эрх мэдэл болон удирдлага.....	4
2	ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.1	Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ.....	5
2.2	Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах нь.....	5
3	АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	6
3.1	Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага.....	6
3.2	Гол уялдаа холбоо.....	7
4	ТӨСЛИЙН СТАНДАРТУУД	8
4.1	Монгол улсын холбогдох хууль тогтоомж, үндэсний стандартууд:.....	8
4.2	БОНБНУ-ний шаардлага.....	9
4.3	МУ-ын Засгийн газар болон төрийн байгууллагуудын бусад үүрэг даалгавар болон шаардлагууд.....	9
4.4	Олон улсын холбогдох стандарт, удирдамж.....	10
	<i>Орчны агаарын чанарын стандарт</i>	10
	<i>Агаарын хийн хаягдлын хүлцэх хэмжээ</i>	10
4.5	Рио Тинто компанийн холбогдох стандарт, удирдамж.....	11
4.6	Төслийн холбогдох стандартуудын тойм.....	11
5	УДИРДЛАГЫН ХЯНАЛТ	17
5.1	Агаарын хийн хаягдлын талаар баримтлах ерөнхий арга барил.....	17
5.2	Хэрэгжилт.....	17
6	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ	23
6.1	Удирдлагын төлөвлөгөөний хяналт ба шинэчлэлт.....	23
7	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	23
7.1	Хяналт шинжилгээ хийх шаардлага.....	23
7.2	Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд.....	23
7.3	Мониторингийн гол хэмжилтүүд.....	24
8	СУРГАЛТ	26
8.1	Ерөнхий тойм.....	26
8.2	Танилцуулах сургалт.....	26

**Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын
төлөвлөгөө**Хүчин төгөлдөр болох огноо:
2013.09.01Баримт бичгийн дугаар:
ОТ-10-Е12-ПЛН-0001-МХувилбар:
2.0

8.3	Ажлын байранд хамаарах сургалт.....	26
8.4	Сургалтын бусад шаардлага.....	26
9	АУДИТ, ТАЙЛАГНАЛ.....	26
9.1	Дотоод аудит.....	26
9.2	Гадаад аудит.....	27
9.3	Гүйцэтгэлийн тайлан.....	27
10	БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ	27

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Зорилго

Энэ удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, удирдлагын холбогдох нэгжүүдийн уялдаа холбоог харуулах;
- ажлын байрны үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн холбогдох стандартууд, удирдамжуудыг тоймлон гаргах;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн үүрэг даалгавар, үйл ажиллагааны журам, удирдамжийг тодорхойлж, энэ төлөвлөгөөнд тусгагдсан Оюу толгой (ОТ) компанийн Байгаль орчны бодлогын шаардлагуудыг тодруулах;
- Гүйцэтгэлийн Гол Үзүүлэлт (ГҮҮ)-ийг багтаасан мониторингийн болон тайлагналтын журмыг тодорхойлох;
- Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ба
- Агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу холбогдолтой нэмэлт материалын лавлагаа, системийн болон үйл ажиллагааны журмууд болон бусад хэрэгцээт мэдээллийг тодорхойлох зэрэг болно.

1.2 Хэрэглээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд дурдсан шаардлагыг Оюутолгойн бүх үйл ажиллагаанд, тэр дундаа гэрээт ажилтнуудын үйл ажиллагаанд мөрдөнө.

Тус удирдлагын төлөвлөгөөг Рио Тинтогийн 2014 оны 6-р сард гаргасан Агаарын чанарыг хамгаалах стандартад үндэслэн гаргасан

Оюутолгой компанийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутаг (ЭМААБОАБОН)-ийн Ерөнхий менежер тус удирдлагын төлөвлөгөөг эзэмшинэ .

1.3 Эхлэх огноо

Тус удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болно.

1.4 Эрх мэдэл болон удирдлага

Оюутолгой компанийн Гүйцэтгэх хороо тус удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр баталсан. Төслийн бүтэц, дүрэм журамд орсон өөрчлөлтийг тусгахаар илүү ойр ойрхон давтамжтайгаар хянан шинэчлэх шаардлагатай болоогүй л бол тус Удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутам хянаж, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт, шинээр мэдээлэл оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Энэхүү Удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах аливаа хүсэлтийг Өөрчлөлтийн Удирдлагын журамд заасны дагуу хянуулж, батлуулна.

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-ПЛН-0001-М	Хувилбар: 2.0

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэ удирдлагын төлөвлөгөө нь Оюутолгой компанийн агаар мандалд хийн хаягдал үүсгэх боломжтой үйл ажиллагаануудад хамааралтай. Агаарт ялгарах зарим хийн хаягдал нь иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх, агаарын бохирдол үүсгэх буюу тоос, эвгүй үнэр үүсгэснээр иргэдийн амьдрах орчны ая тухыг алдагдуулдаг. Зарим төрлийн хийн хаягдал, ялангуяа чулуун нүүрсний шаталтаас үүсэх хийнүүд нь уур амьсгалын өөрчлөлтийг нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлж болно. (ө.х. “хүлэмжийн хий”)

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй Оюутолгой үйл ажиллагаанаас ялгарах гол хийн хаягдалд:

- Тоосны ялгарал, түүний хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, мөн тоос ихэссэнээр хүн, биологийн олон янз байдал, экосистемийн ая тухтай байдлыг алдагдуулах;
- Хүхрийн давхар исэл (SO_2), азотын ислүүд (NO_x), нүүрстөрөгчийн исэл (CO) зэрэг агаар бохирдуулагч хийнүүд, эдгээр бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл ба
- Хүлэмжийн хий (голдуу нүүрсхүчлийн хий CO_2) орно.

Энэ удирдлагын төлөвлөгөө нь Оюутолгой компани болон бусад гэрээт гүйцэтгэгч компаниудын уурхайн лицензит талбайн гадна болон дотор гүйцэтгэх бүх үйл ажиллагаанд хамааралтай.

2.2 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах нь

Энэ удирдлагын төлөвлөгөө нь Оюутолгойн Байгаль орчин, Нийгмийн Удирдлагын Төлөвлөгөө (БОНМТ)-ний ерөнхий бүтцэд тодорхойлогдсон төслийн Ашиглалтын шатны удирдлагын багц төлөвлөгөөний нэг хэсэг юм. (ОТ-10-ПЛН-0003).

Энэ удирдлагын төлөвлөгөө нь агаарын хийн хаягдал ялгарахтай холбогдолтой дараах удирдлагын төлөвлөгөөнүүдтэй давхцах буюу харилцан холбоотой байдлаар боловсруулагдсан. Үүнд;

- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө (RD-10-ПЛН-0001), ялангуяа орон нутгийн иргэдэд тоосжилтоос үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой.
- Тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-ПЛН-0001), ялангуяа уурхайн лицензит талбайн гадна болон дотор зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтыг хянахтай холбоотой.
- Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-ПЛН-0001-Е), ялангуяа газар хөндөх үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосонд өртөж болзошгүй гэж тодорхойлогдсон хүлээн авагчдад үзүүлэх тоосны сөрөг үр дагавараас сэргийлэх эсвэл бууруулахтай холбоотой.
- Гэрээт байгууллагуудын удирдлагын тогтолцоо (ОТ-07-ПЛН-0001-Е), гэрээтүүдийн энэхүү бичиг баримтын хэрэгжүүлэлттэй холбоотой;
- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-ПЛН-0003), төслийн талбайн гадна болон дотор талд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүссэн тоостой холбоотой;
- Эрдэс хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е13-ПЛН-0001-Е), төслийн стандартуудыг хангахтай холбоотой;

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

- Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0003), агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө нь байгаль орчин нийгмийн удирдлагын төлөвлөгөөн нэг болохтой холбоотой;
- Аюултай хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е15-PLN-0001-Е), хүлэмжийн хийн бүртгэлийн хог хаягдлын бүртгэлтэй холбоотой;
- Бэлчээрийн менежмент ба малчдын амьжиггаанд дэмжлэг үзүүлэх удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0013-Е), бэлчээрт үзүүлэх тоосны нөлөөлөлтэй холбоотой.

3 АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1 Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага

Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтнууд болон тэдний үүрэг хариуцлагыг доорх байдлаар тоймлон харуулав.

Хүснэгт 1: Гол хариуцагчид, тэдгээрийн үүрэг хариуцлага

Албан тушаал	Үүрэг хариуцлага
ЭМААБОАБОН хариуцсан ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> • Агаарын чанарын мониторинг хийх, нөлөөллийг бууруулах, судалгаа шинжилгээ хийхэд хүн, тоног төхөөрөмжийн хангалттай хөрөнгө нөөц бүрдүүлэх. • Энэ төлөвлөгөөг гардан хариуцаж ерөнхийд нь хэрэгжүүлэх, мөн гол гэрээт компаниуд энэ төлөвлөгөөний холбогдох хэсгийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй.
Байгаль орчин, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан менежер	<ul style="list-style-type: none"> • Жил бүрийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, мониторингийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг ерөнхийлөн хариуцах. • Агаарын чанар, ололт амжилт зэрэг тухайн жилийн байгаль орчны гүйцэтгэлийг харуулсан байгаль орчны жил тутмын тайланг боловсруулах. • Байгаль орчны хэлтсийн багуудыг шаардлагатай боловсон хүчнээр хангагдсан эсэхийг хариуцах, багуудад дэмжлэг үзүүлэх.
ЭМААБООН-ийн хууль эрхзүйн хэрэгжилтийн баг	<ul style="list-style-type: none"> • Агаар хамгаалах талаарх үндэсний хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хянах, мэдээлэх
Байгаль орчны мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> • Жил бүрийн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн Агаарын чанарын хяналтын хэсгийг боловсруулж хэрэгжүүлж байгаа эсэхийг хянах, орчны агаарын чанарын үзүүлэлт стандарт хэмжээнээс хэтэрсэн үед холбогдох гүйцэтгэгч, үйл ажиллагааны удирдлагад мэдээлэх. • Судалгаа, хяналт шинжилгээ, нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэлийг Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд тайлагнах, Байгаль орчны жилийн тайланд агаарын чанартай холбоотой хэсгийг боловсруулах. • Тус удирдлагын төлөвлөгөөны АГҮ-ийг тогтмол бүртгэж, орсон өөрчлөлт,

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

	<ul style="list-style-type: none"> • шинэчлэлтийг холбогдох оролцогч талуудад тараах • Агаарын чанартай холбоотой сэдэв, асуудлаар сумдын төлөөлөгч, малчидтай тогтмол хийх уулзалтанд оролцох.
Эрүүл мэндийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаанаас үүдэлтэй хорт утааны улмаас үүсэх эрүүл мэндийн аюул эрсдэлийг тодорхойлох эрсдэлийн бүртгэлийг боловсруулж, хөтлөх
Нийгмийн хариуцлагын баг	<ul style="list-style-type: none"> • Зохио байдлаар хянан зохицуулах зорилгоор агаарын чанартай холбоотой гомдол саналыг хянах, мэдээлэх
Ашиглалт болон хангамжийн хэлтсийн менежерүүд, гол гэрээт компаниуд	<ul style="list-style-type: none"> • Холбогдох үйл ажиллагааг энэ удирдлагын төлөвлөгөө, холбогдох журам болон эрсдэлийн үнэлгээний тайлангийн дагуу хэрэгжүүлэх. • Төслийн агаарын чанарын стандартыг мөрдөж байгааг харуулах үүднээс шинэ тоног төхөөрөмж худалдаж авах, хянах техник технологийг ашиглахад мөрдөх худалдан авах ажиллагааны зохио үзүүлэлтүүдийг боловсруулах. Үйлдвэр, тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг Хийн ялгарлыг хянах үзүүлэлтийн дагуу боловсруулж, хэрэгжүүлэх • Осол зөрчлийн хяналт шалгалт явуулж, тайлагнах • Хэлтсийн ажилтнуудад агаарын чанарын удирдлагын арга ажиллагааг бүрэн эзэмшүүлэх. • Осол зөрчлийг магадлан шинжилж мэдээлэх. • Байгаль орчны мэдэгдэл, орчны агаарын чанарын тайланийн мөрөөр шаардлагатай засаж залруулах арга хэмжээг авах. • Рио тинтогийн ЭМААБООН-ийн хэлтэст сар бүр хүргүүлэх тайланд орох ОТ-н хүлэмжийн хий ялгарлын үзүүлэлтийг гаргаж өгөх
Ажлын байрны ахлах ажилтан/ахлах мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> • Энэ удирдлагын төлөвлөгөө, холбогдох журмуудын шаардлагуудыг үйл ажиллагаандаа нийцүүлэн хэрэгжүүлж, энэ талаар ажлын байрны тогтмол үзлэг шалгалтыг хийх. • Орчны агаарын чанарын эрсдэл, тус удирдлагын төлөвлөгөөний үүрэг амлалт, шаардлагад нийцэхгүй байгаа зүйл, болон осол зөрчил зэрэг бүх аюулыг мэдээлэх.
Бүх ажилчид, гэрээт ажилчид	<ul style="list-style-type: none"> • Шаардлагагүй тоосжилт болон хийн хаягдал үүсгэж буй аливаа үйл ажиллагааг мэдээлэх. • Шаардлагагүй тоосжилт болон хийн хаягдал үүсгэж буй аливаа үйл ажиллагааг явуулахаас зайлсхийх.

3.2 Гол уялдаа холбоо

Энэ удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол нэгжүүдэд (өөрөөр хэлбэл энэ удирдлагын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэгчдэд) дараах хэлтсүүд орж байна.

- Дэд бүтцийн хэлтэс, ялангуяа замын дэд бүтцээс үүсэх тоосжилт, дизель цахилгаан үүсгүүр, нүүрсэн галлагаат уурын зуух, төвийн халаалттай станц, хог хаягдлын удирдлагын төвөөс агаарт ялгарах хийн хаягдалд хяналт тавихтай холбоотойгоор.
- Ил уурхайн хэлтэс, ялангуяа ил уурхай, хаягдал чулуулгийн овоолго, хүдрийн овоолго, хөрс хуулах, болон тэсэлгээнээс үүсэх тоосжилтыг хянахтай холбоотойгоор;
- ХХБ, анхдагч бутлуур, Том хүдрийн агуулахаас ялгарах тоосжилтийг хянахтай холбоотойгоор Баяжуулахын хэлтэс болон Хаягдлын удирдлагын баг;

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0
---	--	------------------

- Хангамжийн хэлтэс (ашиглалтын болон гүний уурхай хамтдаа), ялангуяа худалдан авч буй үйлдвэр, тоног төхөөрөмжийн ялгаруулах хийн хаягдлын үзүүлэлтүүд, ялгаруулалтын хязгаартай холбоотойгоор;
- Тээврийн хэлтэс (ашиглалтын болон гүний уурхай хамтдаа), ялангуяа дотогшоо болон гадагшаа чиглэсэн материал тээвэрлэлтээс үүдэлтэй үүсэх ялгаруулалтыг бууруулахтай холбоотойгоор;
- Барилгын хэлтсүүд (Барилга инженерийн болон гүний уурхай хамтдаа), ялангуяа барилгын үйл ажиллагаанаас үүссэн бохирдлыг бууруулахтай холбоотой.

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Төслийн бүх үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг ("Төслийн стандартууд") баримтлах ёстой. Төслийн стандартуудад дараах стандартууд орж байна.

- Монгол улсын холбогдох үндэсний стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-ний шаардлага;
- Монгол улсын Засгийн газар, түүний хэрэгжүүлэгч агентлагуудын шаардлага болон үүрэг даалгаварууд;
- Зээлдүүлэгчийн холбогдох стандарт, удирдамж;
- Рио Тинто компанийн холбогдох стандартууд;
- Оюутолгой компанийн мөрдөх ёстой аж үйлдвэрийн салбарын бусад удирдамжууд.

4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж, үндэсний стандартууд:**Агаарын тухай хууль (2012 оны 6-р сарын 23-нд хүчин төгөлдөр болсон)**

Энэ шинэчилсэн хуулиар эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, одоо болон хойч үедээ байгаль орчны тэнцвэрийг хадгалан үлдээхийн тулд хүрээлэн буй орчны агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Тус хуулиар агаарын бохирдлын тодорхой суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл олгох систем бий болгож, бохирдлын тодорхой түвшинд төлбөр ногдуулдаг. Бохирдлын зөвшөөрлийг орон нутгийн засаг даргаас авах ёстой.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль (2010 оны 6-р сарын 24-нд хүчин төгөлдөр болж, 2012 оны 6-р сарын 23-нд нэмэлт өөрчлөлт оруулсан)

Энэ хуулиар агаарын бохирдлын төлбөр ногдуулж, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Олон улсын стандартын дагуу шинэ болон өргөтгөсөн бүх байгууламжид хүлэмжийн хийг бууруулах технологийг багтаасан хийн хаягдалд мониторинг, бохирдлыг бууруулах технологийг нэвтрүүлэх шаардлагатай. Тус хууль нь агаар мандалд ялгаруулах хийн хаягдлын төлбөрийн системийг мөн хуульчилсан.

Мөн энэ хууль агаар бохирдуулах хийн хаягдлын ялгаруулалтыг зохицуулдаг. Оюутолгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний татварыг тогтвортой байлгах тухай заалтын дагуу Оюутолгой төсөл агаар бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөнө. Гэсэн ч энэ төлөвлөгөө нь агаарын бохирдлын стандартын хувьд энэ хуулийг удаан хугацаанд мөрдөхөд тус дөхөм болно.

Монгол улсын стандартууд

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-ПЛН-0001-М	Хувилбар: 2.0

Төслийн бүх үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг ("Төслийн стандартууд") баримтлах ёстой агаарын чанарыг хамгаалахтай холбоотой Монгол улсын байгаль орчны чанарын дараах стандартууд байдаг.

- MNS (ISO) 4226. 2000 Агаарын чанар - Ерөнхий ухагдахуун; Хэмжих нэгж:
- MNS 4585:2016. Монгол улсын Агаарын чанарын үндэсний стандарт – Агаарын чанарын үзүүлэлт.
- MNS 6298:2011 Шинэ дулааны станц, дулааны станцын яндангаар агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга..
- MNS 5043.2016 4.2 мВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага

Монгол улсын Агаарын чанарын үндэсний стандарт (MNS 4585:2007) нь орон нутагт бус төв суурин газарт зориулсан стандарт юм. MNS 4585:2016-д хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

“Энэхүү стандартыг хот суурин, орон сууц, албан тасалгаа, үзвэр, нийтийн үйлчилгээний газар, иргэний барилга, байгууламжийн төлөвлөлт, ашиглалтын явц дахь гадаад болон дотоод орчны агаарын чанарыг танадах, үнэлэх, хянахад мөрдөнө”.

Үүнээс гадна Дулааны төв станцаас ялгарах бохирдуулагчдад хамараалтай MNS 6298:2011 стандартыг сонгосон.

Ханбумбат нисэх буудлын уурын зуухнаас ялгарах бохирдуулагчдад хамааралтай MNS 5043.2016 стандартыг сонгон авсан.

Энэ удирдлагын төлөвлөгөөг боловсруулах үед дээрх стандартыг хүчин төгөлдөр мөрдөх ёстой шаардлага гэж үзсэн бөгөөд энэ удирдлагын төлөвлөгөөнд хамааралтай байж болох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжийн тоймыг Оюутолгой компаний байгаль орчны хууль тогтоомжийн бүртгэлээс үзнэ үү.

4.2 БОНБНУ-ний шаардлага

БОНБНУ-ний Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны мониторингийн хөтөлбөрт тодорхойлогдсон агаарын хийн хаягдлын удирдлага, хяналт шалгалтын шаардлагуудыг тус удирдлагын төлөвлөгөөний дэд төлөвлөгөө болох Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөөг жил бүр хянаж шинэчлэхэд тусгана.

4.3 МУ-ын Засгийн газар болон төрийн байгууллагуудын бусад үүрэг даалгавар болон шаардлагууд

Үл хамаарна.

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

4.4 Олон улсын холбогдох стандарт, удирдамж

Орчны агаарын чанарын стандарт

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны дараах стандартуудыг Оюутолгой компани хэрэгжүүлэх болно.

- Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын талаарх ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт (2006 он) (ялангуяа ГС1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ, удирдлагын систем, ГС3 Бохирдлоос урьдчилан сэргийлж бууруулах)
- ОУСК-ийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ерөнхий удирдамж (2007 оны 4-р сар) Европын холбооны орчны агаарын чанарын стандарт нь энэхүү баримт бичигт олон улсын стандарт хэмээн орсон байдаг.
- ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (2008 он) (ялангуяа ГШ1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ, удирдлага, ГШ3: Бохирдлоос сэргийлж бууруулах)
- Орчны агаарын чанар болон Европын агаар цэвэршүүлэх асуудлаар Европын Парламент ба Зөвлөлийн хамтран гаргасан 2008 оны 5 дугаар сарын 21 -ны өдрийн 2008/50/ЕС тоот агаарын чанарын шаардлага

ЕСБХБ-ийн Гүйцэтгэлийн стандартын 3 нь бохирдуулагч бодис ялгаруулахаас зайлсхийх, зайлхийх боломжгүй бол ялгаралтын эрчим, их хэмжээний урсгалыг бууруулах, хянахыг шаарддаг. ОУСК-ийн БОЭМАА-ны удирдамжинд (2007 он) тухайн улсад үндэсний стандарт байхгүй тохиолдолд (энэ тохиолдолд үндэсний стандарт байгаа хэдий ч хот суурин газарт зориулагдсан байна) олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандартыг хэрэглэхийг зөвлөсөн байдаг. ЕХ-ны агаарын чанарын стандартыг¹ ОУСК-ийн БОЭМАА-ны ерөнхий удирдамжинд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт хэмээн тодорхойлсон тул энэ төслийн мөрдөх стандартаар сонгосон. Мөн ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 3-ын дагуу төслүүд нь ЕХ-ны холбогдох байгаль орчны шаардлагуудыг хангахуйц байдлаар боловсруулагдсан байх ёстой.

Агаарын хийн хаягдлын хүлцэх хэмжээ

ОУСК нь Оюутолгой төслийн эрхэлдэг хийн бохирдлын эх үүсвэрт зориулсан ерөнхий болон салбарын удирдамжийг гаргасан. Тухайлбал:

- Дизель үүсгүүр гэх мэт түлш шатаадаг тоног төхөөрөмжинд хамаарах ОУСК-ийн БОЭМАА-ны Удирдамж (2007 он)
- Нүүрсээр ажилладаг төвийн халаалттай станц (ТХС), ирээдүйд баригдах цахилгаан станцтай холбоотой ОУСК-оос гаргасан Дулааны цахилгаан станцын БОЭМАА-ны Удирдамж (2008 он)
- Нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станц болон ирээдүйд баригдах цахилгаан станцтай холбоотой ЕХ-ны 2010 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 2010/75/ЕС тоот Үйлдвэрлэлийн хийн хаягдлын (бохирдлоос сэргийлэх болон хянах) Удирдамж.

¹ Европын Парламент ба 2008 оны 5 дугаар сарын 21 -ны өдөр байгуулагдсан Европын цэвэр агаар буюу агаарын чанарын Зөвлөлийн хамтран баталсан зөвлөмж 2008/50/ЕС-д заасан ЕХ-ны агаарын чанарын шаардлага

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-ПЛН-0001-М	Хувилбар: 2.0

Дээр дурьдсанчлан агаар бохирдуулагч бодисуудын харьцуулах төслийн стандартууд нь ОУСК-н БОЭМАА-н дулааны цахилгаан станцуудад зориулсан удирдамж болон Монгол улсын стандарт MNS 6298:2011 Шинэ дулааны станц, дулааны станцын яндангаар агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга-д бичигдсэн аль өндөр шаардлагаар нь тодорхойлогдсон. Дор дурьдсан шалтгаанаар ЕХ-н 2010/75/ЕС тоот үйлдвэрлэлийн хийн хаягдлын бохирдлоос сэргийлэх болон хянах удирдамжаас татгалзсан.

- Төслийн стандарт нь ОУСК-н үнс/тоосны шаардлагад нийцсэн ба SO₂ болон NO_x –н шаардлага нь мэдэгдэхүйц маш бага байна.
- Төслийн стандарт нь Монгол улсын стандартад заасан NO_x –н шаардлага нь тус стандартын алслагдсан газар гэсэн тодорхойлолтонд багтаж байгаа бол SO₂ болон үнс/тоосны шаардлага нь мөн маш бага байна.
- Агаарын тархалтын загварчлалаар одоогийн ашиглаж байгаа 72МВт болон ирээдүйд өргөтгөх 130МВт зуухнаас үүсэх бохирдуулагчийн хүлээгдэж байгаа гадаргын төвшний концентраци нь ЕХ-ны 2008/50/ЕС удирдамжинд тодорхойлсон хүрээлэн буй орчны агаарын чанарын шаардлагын 1,4 хувиас бага байгаа нь тогтоогдсон.
- ЕХ-ны шаардлагуудад хүрэхийн тулд Дулааны төв станцын 130МВт болгон өргөтгөх ажил нь утааг хүхэргүйжүүлэх болон азотгүйжүүлэх технологиудыг нэвтрүүлэхийг шаардаж болно. Эдгээр технологиуд нь мөн одоогийн 72МВт-н станцад хэрэгжих шаардлагатай ч байж болно.
- Агаарын тархалтын загварчлалаар бохирдуулагчийн гадаргын төвшний концентраци нь холбогдох ЕХ-ны агаарын чанарын хязгаараас 1.4 хувиас бага, Монгол улсын агаарын чанарын стандартаас 2.5 хувиар бага байгаа нь тогтоогдсон тул утааг хүний эрүүл мэндтэй ямар нэгэн эерэг холбогдол бүхий сайжралтуудыг хүхэргүйжүүлэх болон азотгүйжүүлэх технологиуд нь гаргахгүй байж болно.
- Утааг хүхэргүйжүүлэх технологи нь хүлэмжийн хийг нэмэгдүүлэх, усны хэрэглээг нэмэгдүүлэхэд хүрч болох бөгөөд эдгээр байгаль орчны сөрөг үр дүнгүүд нь төслийн усыг ариглан хамгаалах болон хүлэмжийн хийг бууруулах байгаль орчны зорилтуудтай зөрчилдөх болно.
- Утааг азотгүйжүүлэх технологи нь хортой аммонийн хэрэглээг шаардаж болно. Энэ нь ЭМААБО-н удирдлагын алс хэтийн төлөвлөгөөнд үл нийцэж болно.
- Дулааны төв станцын 130МВт-н өргөтгөлд тоног төхөөрөмж нийлүүлэгчид нь тэдний хангаж буй багаж тоног төхөөрөмжүүдээ төслийн стандартад нийцэж буй гэж баталгаагаар хангах шаардлагатай.

4.5 Рио Тинто компанийн холбогдох стандарт, удирдамж

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагад хамаарах Рио Тинто компанийн гол стандарт бол *E12 Агаарын чанарыг хамгаалах стандарт (2014 оны 6-р сар)* юм.

Энэ төлөвлөгөөтэй холбоотой Рио Тинто компанийн баримт бичгүүдэд:

- ЭМААБОЧ-ын удирдлагын системийн стандарт (E1)
- Газар хөндөх, нөхөн сэргээхэд хяналт тавих стандарт (E14) орно.

4.6 Төслийн холбогдох стандартуудын тойм

Оюутолгой компани зээлдүүлэгчийн холбогдох стандарт, Рио Тинто компанийн холбогдох стандарт, үндэсний стандартуудаас хамгийн хатуу шаардлагатайг нь төслийн стандартаар сонгон мөрдөх болно.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

Хийн хаягдлын хүлцэх хэмжээ

Монгол улсын хуулинд хийн хаягдлын хүлцэх хэмжээг тодорхолоогүй байдаг. Хийн хаягдлын төслийн стандартыг доор үзүүлэв. Хийн хаягдлын цэгэн үүсвэрийн төслийн стандартыг АЧХШТ-ний Хавсралт А-д үзүүлсэн.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

Хүснэгт 2: Хөдөлгөөнгүй эх үүсвэрээс агаар мандалд ялгарах хийн хаягдлын төслийн стандарт

Эх үүсвэр	Бохирдол	Стандарт (мг/м ³)				Тайлбар
		Төслийн стандарт	MNS	ОУСК ⁵	ЕХ ⁶	
Диезель генератор	NO _x	1460 ¹ 1,850 ²	ҮХ	1460 ¹ 1,850 ²	ҮХ	Төслийн генераторууд нь 2мВт ба түүнээс бага хүчин чадалтай бөгөөд ОУСК-ын стандартын хязгаар нь (3-50MW) болохыг анхаарна уу. Диезель генераторууд нь эрчим хүчний яаралтай нэмэлт тоноглол бөгөөд жилд 500 цаг ажиллах хүчин чадалтайг анхаарна уу.
	Жижиг хэсэг (PM)	50 ³	ҮХ	50 ³		
	Шатахууны S агууламж (%)	Хамгийн бага боломжит утга	ҮХ	1.5%		
Дулааны цахилгаан станц ^{7, 8}	NO _x	300	450-1100	510	200-300	Монгол улсын стандартын хязгаар нь нүүрсэн дэх ууршигтай бодисын агууламж (NO _x) болон хот суурин/алслагдмал газрын тодорхойлолт (SO ₂ ба PM)-д суурилдаг. ОУСК-н үзүүлэлтүүд нь хаалттай агаарын урсгалд суурилдаг. ЕХ-ны үзүүлэлтүүд нь 50-100мВт (одоогийн) болон 100-300мВт (өргөтгөлийн дараах) хүлцэх хэмжээнүүдэд суурилсан. Үр дүнг 1013мбар, 273К, 6 хувь хүчилтөрөгч бүхий хуурай агаарын нөхцөлд гэж засна. NO _x нь NO ₂ -г илэрхийлнэ.
	SO ₂	400	400-600	900-1500	250-300	
	PM	50	50-200	50	25-30	

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

Эх үүсвэр	Бохирдол	Стандарт (мг/м ³)				Тайлбар
		Төслийн стандарт	MNS	ОУСК ⁵	ЕХ ⁶	
Нүүрсээр ажилладаг уурын зуух ⁹	NO _x	450	450	650	400 ⁸	Орон нутгийн уурын зуухууд ашиглалтаас гарсан. Ханбумбат нисэх буудалд нэг уурын зуух ажиллаж байгаа бөгөөд энэ нь 0.5 мВт хүчин чадалтай. ОУСК-н хязгаар 3.5мВт ба ЕХ-ны хязгаар 50-100мВт болохыг анхаарна уу. .
	SO ₂	800	800	2000	850	
	PM	500	500	50 ⁴	100	

Тайлбар

¹ цооногийн хэмжээ, диаметр [мм] < 400

² цооногийн хэмжээ, диаметр [мм] > эсвэл = 400

³ хэрэв төслийн онцлогт тохируулж авч үзвэл 100 хүртэл

⁴ хэрэв байгаль орчны үнэлгээнд тохируулж авч үзвэл 150 хүртэл

⁵ ОУСК-аас генератор болон бойлуурын зөвшөөрөгдөх дулааны хэмжээ нь 3-50MW байна.

⁶ Хийн хаягдлын холбогдох монгол стандарт байхгүй

⁷ ЕХ-ны 2001/80/ЕС тоот Том Цахилгаан Станцын Удирдамж

⁸ ЕХ-ны 2010/75/EU тоот Үйлдвэрийн хийн хаягдлын Удирдамж

⁹ MNS 5043.2016 4.2 мВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага

Бохирдуулагч хийн хаягдал ялгаруулдаг төхөөрөмжүүдийн ялгаралалтын хүлцэх хэмжээ болон хууль тогтоомжийн дагуу хийгдэх хяналт шинжилгээний давтамжийг Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөөнд тодорхойлсон ба дараахи хүснэгтээр үзүүлэв.

Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е12-PLN-0001-М	Хувилбар: 2.0

Хүснэгт 3: Гол хийн хаягдлын эх үүсвэрүүд

Эх үүсвэр	Анхан шатны байдлаар авч үзэх хийн хаягдал
Яаралтай үед ашигладаг Дизель генераторууд	Азотын ислүүд (NO _x), хүхрийн давхар исэл (SO ₂), нүүрстөрөгчийн давхар исэл (CO ₂), бусад макро хэсэг (PM)
Хог хаягдлын удирдлагын төв	NO _x , SO ₂ , CO ₂ , макро хэсэг, кадми
Орон нутгийн нүүрсээр ажилладаг уурын зуухнууд	NO _x , SO ₂ , CO ₂ , макро хэсэг
Дулааны цахилгаан станц : Нүүрсэн галлагаатай циркуляцаар шингэрүүлдэг бойлуурууд (CFB)	NO _x , SO ₂ , CO ₂ , макро хэсэг
Уурхайн талбайн дотор болон гадна ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүд (дотогшоо болон гадагшаа тээврийг багтаасан)	NO _x , SO ₂ , CO ₂ , макро хэсэг (яндангаас нь ялгарах), тоосжилт (дугуйнаас үүсгэгдэх)
